

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026.04.28

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурлыг, хурал хийхээр товлосон зарын дагуу 2026.04.28-ны өдрийн 14 цагт Компанийн хурлын танхимаас цахим хэлбэрээр шууд дамжуулав.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын Комиссын 2026.04.28-ны өдрийн "Хүчин төгөлдөрт тооцох тухай" №01 тоот тогтоолыг тооллогын комиссын дарга Г.Энх-Оюун уншиж танилцуулав. / Уг тогтоолыг хурлын материалд хавсаргав./

Тооллогын Комиссын дарга Г.Энх-Оюун: Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд 1.023.703 ширхэг хувьцаа эзэмшсэн 4000 хувьцаа Эзэмшигчдээс саналын эрх бүхий 894.191 ширхэг хувьцаа эзэмшсэн 140 хувьцаа эзэмшигч бүртгэгдсэн байна. Энэ нь нийт хувьцааны 87 % -ыг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн "Хурал хүчин төгөлдөрт тооцсугай" гэв.

Мөн манай компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026.03.13-ны өдрийн "Хурал хуралдуулах тухай" тогтоолд санал авах сүүлийн хугацааг 2026.04.28 ны өдрийн 14 цагаар тогтоож өгсөн, бид 14 цагт хурал эхлэнгүүт саналыг тасалбар болгон "Хурал хүчин төгөлдөрт тооцох тогтоол"-ыг гаргалаа. Тогтоолыг гаргаж, уншсанаас хойш саналаа өгсөн бол хүчингүйд тооцно гэдгийг онцлон тэмдэглэлээ.

Үүний дараа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын /Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон / даргаар томилогдсон Б.Гандулам хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ирэх боломжгүй тул тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Баярсайхан хурлыг нээж үг хэлэв.

Хурлын дарга Д.Баярсайхан: Хувьцаа эзэмшигч та бүхэн маань "Талх Чихэр" ХК-ийн пэйж хуудсанд хандан цахимаар хурлын үйл ажиллагаанд оролцохыг урьж байна гэв. Дараа нь хурлын дэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга болон тооллогын комиссыг танилцуулж ажилдаа орохыг урив.

Хурал даргалагч Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн 2026 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнийг нөхөн сонгох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсвийг батлах
4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 450 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалал ёсоор:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн 2026 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал Б.Оргил илтгэв.
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг компанийн ерөнхий нягтлан бодогч И.Түвшинжаргал тайлагнав.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг танилцуулав.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч Эрдэнэбат овогтой Цэцэглэнгийн танилцуулгыг Нэр дэвшүүлэх хорооны дарга Д.Баярсайхан танилцуулав.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн "Ногдол ашиг хуваарилах" тухай тогтоолыг танилцуулав.

Хурлын дарга : Хэлэлцэх асуудал үүгээр дууслаа. Хувьцаа эзэмшигчдийн асуулт хариултанд холбогдох албан тушаалтнууд хариулах болно.

Асуулт: FSSC-22000 стандартыг нэвтрүүлснээр танай компанийн өдөх тутмын ажилд яг ямар өөрчлөлт гарсан бэ ?

Хариулт : Лаборатори, Чанар хяналтын албаны дарга Э.Бадамгарав :

Энэ стандарт нь хүнсний аюулгүй байдлын иж бүрэн тогтолцоо бөгөөд ISO-22000 стандартын шаардлагуудыг суурь болгон ашигладаг. Энэ стандартад хүнсний луйвар, хуурамч бүтээгдэхүүнээс урьдчилан сэргийлэх, хүнсний хамгаалалтын нэмэлт шаардлагууд байдаг ба энэ хүрээнд үйлдвэрлэлд түүхий эдийн хяналт өргөн хүрээнд хийгддэг болсон . Өөрөөр хэлбэл ашиглаж буй түүхий эд материал дээр эрсдлийг үнэлж эрсдэлд суурилсан хяналтыг хийдэг болсон гэж ойлгож болно.

Асуулт : Сүүлийн үед хэрэглэгчийн худалдан авалт өөрчлөгдөж байна. Та нар үүнд яаж нийцүүлж байна вэ?

Хариулт: Гүйцэтгэх захирал Б.Оргил :

Сүүлийн үед хэрэглэгчийн худалдан авалтын чиг хандлага эрүү, органик бүтээгдэхүүн рүү илүү чиглэж байна. үүнтэй уялдуулан бид бүхэл үрийн болон хөх тарианы зэрэг органик бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, зах зээлд түлхүү нэвтрүүлэн ажиллаж байна.

Асуулт : Жен Z үеийнхний ажиллах хандлагын өөрчлөлтөд хэрхэн дасан зохицож байна вэ? Энэ үеийнхний онцлогийг хүлээн зөвшөөрч, дэмжин ажиллаж байна уу?

Хариулт : Талх Чихэр ХК-ийн Гүйцэтгэх захирал О.Оргил

Бид энэ үеийнхний онцлог, хэрэгцээг харгалзан дижитал харилцаа, эрүүл амьдралын хэв маягт нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, тэдний оролцоог дэмжин ажиллаж байна.

Хурлын дарга : За хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултанд холбогдох албан тушаалтнууд хариуллаа. Хувьцаа эзэмшигч та бүгдэд баярлалаа. Одоо түр завсарлая, тооллогын комиссыг ажилдаа орохыг урья гэв.

Үүний дараа тооллогын комиссын дарга Г. Энх-Оюун " Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах тухай" Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг уншиж танилцуулав./ уг тогтоолыг хурлын материалд хавсаргав.

Тооллогын комиссын дарга Г.Энх-Оюун : Компанийн нийт 1,023,703 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4000 хувьцаа эзэмшигчдээс хуралд 894.191 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 140 хувьцаа эзэмшигч оролцов

Тооллогын комисст ирсэн саналын хуудас 140 ширхэг, үүнээс асуулга тус бүрээр хүчинтэй саналын хуудас 139 , асуулга тус бүрээр хүчингүй саналын хуудас 1 байна. 894.191 ширхэг хувьцаа эзэмшсэн 139 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчинтэйд, 70 ширхэг хувьцаа эзэмшсэн 1 хувьцаа эзэмшигчийн саналын хуудсыг хүчингүйд тооцов. Асуулга бүрээр саналын хуудсыг тоолоход :

1. Компаний 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлахыг зөвшөөрсөн 894.121 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,99 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.
2. Компанийн 2026 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 894.121 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.99 хувь, татгалзсан , түдгэлзсэн санал байхгүй
3. ТУЗ-ийн ердийн гишүүнээр:
 1. Эрдэнэбат овогтой Цэцэглэнг сонгохыг зөвшөөрсөн 894.121 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,99 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй
 - 2026 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 95.790.000 батлахыг зөвшөөрсөн 894.121 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,99 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй
4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 450 төгрөгөөр хувиарлахыг зөвшөөрсөн 894.121 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,99 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй гэсэн дүн гарлаа. Дүнг үндэслэн ТОГТООХ НЬ: Дээрх хэлэлцсэн асуудлаар Тогтоол гаргуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай. гэж уншиж танилцуулав.

Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас №01 тоот тогтоол гаргаж, Хурлын дарга уншиж танилцуулав.

Хурлын дарга : Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ :

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.

2. Компанийн 2026 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг 95.790.000 төгрөгөөр баталсугай.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Эрдэнэбат овогтой Цэцэглэнг компанийн дүрэмд зааснаар 3 жилийн хугацаатай сонгосугай.
4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 450 төгрөг байхаар тогтоосугай гэж уншсанаар хурлын үйл ажиллагаа өндөрлөв.

Хурлын дарга

Тэмдэглэсэн



Д. Баярсайхан

И.Өлзийбаяр